

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

АУДИТЫН КОД: ТӨА-2023/13/НА-СТА-ОНА

ЗААМАРЫН ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод хот 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ихмонгол хөлөг Аудит ХХК

Утас: 70001778 Цахим хаяг: info@imkaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	5
Аудитын гол асуудал	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Компани түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин:	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Албан шаардлага.....	15
5.2 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	18
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	19
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.03.16 № 01/220
танай _____-ны № _____-т

**ЗААМАР ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ТУНГАЛАГ ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Заамар хөгжлийн төв ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон 518.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын 1.9 заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- Санхүүгийн төлөвлөгөө боловсруулаагүй, захиралтай гэрээ байгуулаагүй, ажлын тайланг хэлэлцэн батлаагүй;
- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолгүй 387,421.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан;
- Тайлант хугацаанд 3 байгууллагын 1,461.5 мянган төгрөгийн авлага, 3 байгууллагын 12,549.3 мянган төгрөгийн өглөг, нийт 6 байгууллагын 14,010.8 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Кассын орлого, зарлагын 23 удаагийн 27,274.9 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтгүй бүртгэж, тайлагнасан;
- Кассын 7,610.0 мянган төгрөгийн үлдэгдэлд тооллого хийж, тооцоо бодоогүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Заамар хөгжил ОНӨААТҮГ нь тайлант онд орон нутгийн өмчийг 387,421.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан байна.

19040228

Аудитын гол асуудал

Удирдах зөвлөлөөс Заамар хөгжил ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг батлаагүй байна. Гүйцэтгэлээр 82,102.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 74,080.4 мянган төгрөгийн зардал гарган, 8,021.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Заамар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 16 дугаар тогтоолоор Сумын дэд бүтэц, аж ахуйн үйл ажиллагааг бие даан эрхлэн явуулахаар Заамар хөгжил ОНӨААТҮГ-ыг Заамар хөгжил ОНААТҮГ-ыг үүсгэн байгуулсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	20,000.00	22,816,078.24
1.1.2	Дансны авлага		450,000.00
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал		
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	20,000.00	24,277,567.24
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө		383,105,058.00
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		383,105,058.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20,000.00	407,382,645.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		10,262,019.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өглөг		2,287,305.04
2.1.1.4	НДШ-ийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		12,549,324.05
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн	20,000.00	387,441,766.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг		
2.3.10	Тайлант үеийн ашиг алдагдал		7,391,555.19
2.3.11	Эздийн өмчийн дүн	20,000.00	394,833,321.19
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20,000.00	407,382,645.24

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	82,102,314.44
2	Борлуулалтын өртөг	-	35,602,288.00
3	Нийт ашиг (алдагдал)	-	46,500,026.44
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	38,478,107.75
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	8,021,918.69
19	Орлогын татварын зардал	-	630,363.50
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	7,391,555.19
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	7,391,555.19

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/				
№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
9	2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	20,000.00		20,000.00
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	20,000.00		20,000.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	7,391,555.19	7,391,555.19
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	387,421,766.00	-	387,421,766.00
15	Зарласан ногдол ашиг	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-
17	2022 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	387,441,766.00	7,391,555.19	394,833,321.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	82,937,705.35
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	82,937,705.35
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.2	Мөнгөн зардлын дүн (-)	-	41,677,715.74
1.2.1	Ажилчдад төлсөн	-	11,850,022.69
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	3,341,992.42
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	-	9,291,038.63
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	17,699.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	1,089,563.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	-	16,087,400.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	-	41,259,989.61
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	10,452,440.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зардлын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээд авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	10,452,440.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4		-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	28,916,351.37
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	28,916,351.37
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5		-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	18,463,911.37
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	22,796,078.24
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,000.00
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	22,816,078.24

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани түүний үйл ажиллагаа

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1-т Газар нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр сумын хэмжээнд явуулна. Үүнд:

- Хог хаягдлыг ангилан ялгах, зориулалтын дагуу булах, булшлах;
- Цэвэр, бохир усны шугам сүлжээний засвар, хамгаалалт;
- Орон нутгийн зам, замын байгууламжийн засвар, арчлалт, замын тэмдэг тэмдэглэгээ;
- Малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх
- Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх;
- Гэрэлтүүлэг;
- Суурьшлын бүсийн тохижилт;
- Байгаль орчны нөхөн сэргээлт;
- Бусад

3.2 Компанийн гадаад, дотоод орчин:

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Заамар хөгжил ОНӨААТҮГ нь Заамар сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 16 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4-т "Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.;..." гэсэн заалттай нийцэж байна.

"Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж заасан байна.

Тайлант тус газрын засаглалыг сайжруулах, эдийн засгийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлаагүй, захиралтай гэрээ байгуулаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ";
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол;

- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын *мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар* :

Тус байгууллага нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Заамар хөгжил ОНӨААТҮГ нь 2022 оны 6 дугаар сарын 09-ний өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний 000254713 тоот, хувийн хэргийн 1414001016 тоот дугаар авч бүртгүүлсэн байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 407,382.7 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	20.0	22,816.1	22,796.1
Дансны авлага	-	450.0	450.0
Үндсэн хөрөнгө	-	383,105.1	383,105.1
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	20.0	407,382.6	407,362.6
Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	12,549.3	12,549.3
Төрийн өмч	20.0	387,441.8	387,421.8
Тайлант үеийн ашиг алдагдал	-	7,391.6	7,391.6
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	20.0	407,382.6	407,362.6

Дээрх хүснэгтээс харахад, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, эздийн өмчийн дансны үлдэгдэл өмнөх оноос өссөн байна.

Энэ нь тус байгууллага нь тайлант хугацаанд Төв аймаг дахь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хэлтэст бүртгүүлж үйл ажиллагаагаа явуулснаас нийт хөрөнгийн хэмжээ 407,362.6 мянган төгрөг болж өссөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Заамар хөгжил ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Удирдах зөвлөлөөс Заамар хөгжил ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг батлаагүй байна. Гүйцэтгэлээр 82,102.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 74,080.4 мянган төгрөгийн зардал гарган, 8,021.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Заамар хөгжил ОНААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх Заамар хөгжил ОНААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Заамар хөгжил ОНААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаа Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 74,080.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 740.8 мянган төгрөгөөр тогтоосны 70 хувиар гүйцэтгэлийн материаллаг байдлыг 518.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Заамар хөгжил ОНААТҮГ-ын Зорилтот түвшний төлөвлөгөөг батлаагүйгээс төсвийн хэмнэлт бодитой гарсан гэж үзэхээргүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг байршуулаагүй Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 6 удаагийн 90,566.2 мянган төгрөг, зарлагын 5 удаагийн 37,821.8 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "... хөрөнгө, мөнгө зарцуулах, ... шийдвэр", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-т "Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээлэл, төрийн эрх бүхий байгууллагаас тухайн хуулийн этгээдэд ногдуулсан аливаа акт, албан шаардлага, зөрчлийн хэрэг, тэдгээрийн шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, тайлагнал ба тодруулга батламж мэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Заамар хөгжил ОНААТҮГ-д завсрын аудитыг хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Заамар хөгжил ОНӨААТҮГ-т 2021 оны санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар зардлын тооцоолол, эзэмшигчийн өмчийн талаар гаргасан шийдвэрүүдийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,095.4 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 6,095.4 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Санхүүгийн тайланг толилуулахдаа Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан маягтын дагуу санхүүгийн тайлан, тодруулгыг иж бүрэн бэлтгээгүй;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд 2 байгууллагын 6,095.4 мянган борлуулалтын орлогыг тайлагнаагүй;

Аудитаар нийт 483,145.9 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс, 436,317.2 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 46,828.7 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

5.1.1 Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулаагүй, захиралтай гэрээ байгуулаагүй, ажлын тайланг хэлэлцэн батлаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;”, 19 дүгээр зүйлийн 19.1-т “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг /цаашид “захирал” гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана:” 19.2-т “Эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин;” Заамар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 27 дугаар тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т “Газрын тухайн жилийн бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөл, зорилтын саналыг хэлэлцэж батална.” 7.10-т “Газрын үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулахад шаардагдах хөрөнгийг батлан, контрактын зорилтот түвшинд тусган шийдвэрлэнэ.” 8 дугаар зүйлийн 8.1.1-д “ Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, газрын дүрэм, зорилтын талаар санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолгүй 387,421.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн “Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга шийдвэрлэнэ.” заасантай нийцээгүй мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.1.3 Тайлант хугацаанд 3 байгууллагын 1,461.6 мянган төгрөгийн авлага, 3 байгууллагын 12,549.3 мянган төгрөгийн өглөгийн нийт 6 байгууллагын 14,010.8 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.1.4 Кассын орлого, зарлагын 23 удаагийн 27,274.9 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтгүй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй," гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.1.5 Кассын 7,610.0 мянган төгрөгийн үлдэгдэлд тооллого хийж, тооцоо бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын эрх үүрэг, үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллах.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналтын төлөвлөгөө, ажиллах журамгүй, дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын онцлогт тохирсон дотоод хяналтын журмыг боловсруулж, мөрдөж ажиллах.

3. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын Шалгагдагч байгууллага нь 13 удаагийн 34,692.5 мянган төгрөгийн нэхэмжлэхгүй гүйлгээ хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнахгүй байх.

4. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системийн дүнтэй тулгахад 5 иргэн, байгууллагын 12,136.2 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримт илүү бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", заалтуудтай нийцээгүй, үнэлгээ, нийцсэн бөгөөд зохистой байх, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг илгээхдээ худалдан авалтын төлбөрийн баримтыг тулгаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дүгээр сарын 15 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг толилуулахдаа Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан маягтын дагуу санхүүгийн тайлан, тодруулгыг иж бүрэн бэлтгээгүй	1	-	-	-	1	-	1	-	-	-	-	-
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд 2 байгууллагын 6,095.4 мянган борлуулалтын орлогыг тайлагнаагүй	1	6,095.4	-	-	1	6,095.4	1	6,095.4	-	-	-	-
Дүн	2	6,095.4	-	-	2	6,095.4	2	6,095.4	-	-	-	-

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Заамарын хөгжил ОНӨААТҮГ нь үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулаагүй, захиралтай гэрээ байгуулаагүй, ажлын тайланг хэлэлцэн батлаагүй байна	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолгүй 387,421.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна.	1	387,421.5	-	-	1	387,421.5	-	-	-	-	-	-
Тайлант хугацаанд 3 байгууллагын 1,461.6 мянган төгрөгийн авлага, 3 байгууллагын 12,549.3 мянган төгрөгийн өглөгийн нийт 6 байгууллагын 14,010.8 мянган төгрөгийн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	14,010.8	-	-	1	14,010.8	-	-	-	-	-	-
Кассын орлого, зарлагын 23 удаагийн 27,274.9 мянган төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтгүй тайлагнасан байна.	1	27,274.9	-	-	1	27,274.9	-	-	-	-	-	-
Кассын 7,610.0 мянган төгрөгийн үлдэгдэлд тооллого хийж, тооцоо бодоогүй байна.	1	7,610.0	-	-	1	7,610.0	-	-	-	-	-	-
Байгууллагын онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дотоод хяналтын төлөвлөгөө, ажиллах журамгүй, дотоод хяналт хийгдээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Байгууллагын Шалгагдагч байгууллага нь 13 удаагийн 34,692.5 мянган төгрөгийн нэхэмжлэхгүй гүйлгээ хийсэн байна.	1	34,692.5	-	-	-	-	1	34,692.5	-	-	-	-
Худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системийн дүнтэй тулгахад 5 иргэн, байгууллагын 12,136.2 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримт илүү бүртгэсэн байна.	1	12,136.2	-	-	-	-	1	12,136.2	-	-	-	-
Дүн	9	483,145.9	-	-	5	436,317.2	4	46,828.7	-	-	-	-

Заамар хөгжил ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг байршуулаагүй Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 6 удаагийн 90,566.2 мянган төгрөг, зарлагын 5 удаагийн 37,821.8 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна.	1	128,388.1	-	-	1	128,388.1	-	-
Дүн	1	128,388.1	-	-	1	128,388.1	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	128,388.1	-	-	1	128,388.1	-	-